

“7-р сарын 1. Хэвлэл мэдээллийн мониторинг”

Тав. Зөвлөмж

7 сарын 1-ний үйл явдалтай холбоотой хэвлэл мэдээллийн мониторингийн дүгнэлтэд үндэслэн дараахь зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

УИХ-д:

- Онц байдлын тухай хуульд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох тухай зүйл заалтыг Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуульд нийцүүлэн өөрчлөх
- Олон нийтийн радио, телевиз онц болон дайны байдлын үеэр мэдээлэл, сурвалжлах өөрийн журамтай байхаар ОНРТ-ийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах

ХМХ, сэтгүүлчдийн мэргэжлийн эвлэл холбоодод:

- Зөрчилт байдлын үед сэтгүүлчдийн баримтлах зарчим боловсруулж мөрдөх
- Иргэдийн дуу хоолой болж, тэдний эрх ашигт үйлчилдгийн хувьд зөрчилт байдлын үед гарч болзошгүй хүний эрхийн зөрчлийн баримтыг илрүүлэх, бодитой мэдээлэх, болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах
- Хүний эрхийн асуудлыг мэдээлэх, сурвалжлахад сэтгүүлчдийн баримтлах зарчмыг баталж, мөрдөх